



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 1105

Улаанбаатар хот


Аргачлал батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Мэргэжлийн болон давтан сургалт”-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.


2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /Б.Мөнхцэцэг/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ТУНГАЛАГ

Нийслэлийн хөдөлмөрийн газрын  
даргын 2014 оны дүгээр сарын 10-ны  
едрийн А/01 тоот тушаалын хавсралт



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлалын зорилго: Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийн байдлыг бүхий л хүрээнд ололт амжилт, учирч буй бэрхшээлүүдийн хамт үнэлэн дүгнэж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хүрсэн үр дүн, цаашид авах арга хэмжээний чиглэлд тодорхой санал, зөвлөмжүүдийг дэвшүүлэхэд энэхүү зорилго оршино.

Хяналт-шинжилгээ үнэлгээний үйл ажиллагаа нь баталгаатай, баримтжуулсан мэдээлэл мөн бөгөөд мэдээ баримтыг хэрхэн олж авахтай холбоотой нэн чухал асуудал нь аргачлал юм.

Хяналт-шинжилгээ үнэлгээний амжилт нь аргачлалыг хэрхэн зөв сонгож хэрэгжүүлэхтэй шууд холбоотой гэж үзвэл энэ асуудлын ач холбогдол тодорхой харагдана.

Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тухайн хөтөлбөрийн суурь үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх үр дүнг үндэслэн тогтооно.

Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна: Үүнд:

- Хамааралтай буюу ач холбогдолтой байх
- Урт хугацаанд хэрэглэгдэх, тогтмол байх
- Хэрэглэхэд хялбар, боломжтой байх
- Аль болох богино хугацаанд өөрчлөлтийг илэрхийлэхээр байх

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн “Мэргэжлийн болон давтан сургалт”-ын хүрээнд хянах шалгуур үзүүлэлтүүд:

*Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дараах шалгуур үзүүлэлтүүдийг авч үзнэ: Үүнд:*

- Сургалтанд суухыг хүссэн хүсэлт байгаа эсэх;
- Дүүргийн хөдөлмөрийн хэлтсээс бүртгэлтэй ажилгүй иргэнийг тодорхойлсон маягт байгаа эсэх;
- Цахим үнэмлэхний хуулбар байгаа эсэх;
- Санхүүгийн тооцоолол зөв хийгдсэн эсэх;
- Суралцагчийн эрхийн бичиг дээрхи гарын үсэг болон бүртгэлийн дэвтэр дээрхи гарын үсэг зөрсөн эсэх;

- Бүртгэлийн дэвтэр дээр багшийн хичээлийн агуулга, цаг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааны талаархи хэсэг бөглөгдсөн эсэх;
- Төлөвлөгөөнд тусгагдсан хичээл заах багш нар өөрчлөгдсөн эсэх;
- Нэг хүнд ногдох зардлын хэмжээг зөв тооцоолсон эсэх;

*Гадаад хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дараах шалгуур үзүүлэлтүүдийг авч үзнэ: Үүнд:*

- Гэрээний дагуу хэрэгжиж байгаа эсэх;
- Сургалтын стандарт, нөхцлийг хангасан онолын болон дадлагын байртай эсэх;
- Суралцагчидад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин бүрдсэн эсэх;
- Багшийн хичээл заах арга зүй, ур чадвар, гарын авлага бэлтгэгдсэн эсэх;
- Сургалтын хөтөлбөрийн дагуу нэгж, ажилбарууд, модулиар хичээл явагдаж байгаа эсэх;
- Эрх зүйн орчин болон хөндлөнгийн шинжээчийн хийсэн үнэлгээ, дүгнэлт;
- Шинэ техник, технологи, инноваци нэвтэрсэн байдал;
- Ажлын байрны өсөлт, бууралтын түвшин;
- Суралцагчийн үнэлгээ /санал асуулгаар/;
- Сургалтын байгууллагуудын хаяг тодорхой байгаа эсэх;
- Ажил олоход хүндрэлтэй иргэнд зориулсан тусгай хөтөлбөртэй эсэх ;

Мөн хөтөлбөрийн мэдээлэл иргэдэд хүрсэн байдлыг байгууллагын болон олон нийтийн мэдээллийн самбарт байршуулсан, хөтөлбөрийн үр шимийг хүртэгчдээс мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, сонинд гарсан нийтлэл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон туршлагын сурталчилгаа зэргийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулсан байдлаар хянана.

Баримт бичиг судлах, холбогдох сургалтын байгууллагын захирал, менежертэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

Сургалтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ нь шалгуур үзүүлэлтийн хувь болон онооны нийлбэрийг нийт үзүүлэлтэд хувааж гаргасан дундаж хувь оноогоор илэрхийлэгдэнэ.

Ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан арван сургалтын байгууллагыг хамгийн сайн үнэлэгдсэнээр тооцно.

## /Сургалтын байгууллагын нэр/

№	Шалгуур үзүүлэлтүүд		Үр дүнгийн үнэлгээ	
			хувь	оноо
1	Баримт бичгийн бүрдүүлэлт	Сургалтанд суухыг хүссэн хүсэлт		Авбал зохих оноо 10.0
		Дүүргийн хөдөлмөрийн хэлтсээс бүртгэлтэй ажилгүй иргэнийг тодорхойлсон маягт		
		Цахим үнэмлэх		
	<i>Дундаж үнэлгээ</i>			
2	Санхүү	Санхүүгийн тооцоолол зөв хийгдсэн эсэх		Авбал зохих оноо 20.0
		Нэг хүнд ногдох зардлын хэмжээг зөв тооцоолсон эсэх		
	<i>Дундаж үнэлгээ</i>			
3	Гэрээний нөхцөл	Суралцагчийн эрхийн бичиг дээрхи гарын үсэг болон бүртгэлийн дэвтэр дээрхи гарын үсэг зөрсөн эсэх		Авбал зохих оноо 20.0
		Төлөвлөгөөнд тусгагдсан хичээл заах багш нар өөрчлөгдсөн эсэх		
		Сургалтын хөтөлбөрийн дагуу		
		нэгж, ажилбарууд, модулиар хичээл явагдаж байгаа эсэх		
		Багшийн хичээл заах арга зүй, ур чадвар, гарын авлага бэлтгэгдсэн эсэх		
		Ажил олоход хүндрэлтэй иргэнд зориулсан тусгай хөтөлбөртэй эсэх		
<i>Дундаж үнэлгээ</i>				
4	Эрүүл аюулгүй байдал	Сургалтын стандарт, нөхцлийг хангасан онолын болон дадлагын байртай эсэх		Авбал зохих оноо 10.0
		Суралцагчидад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин бүрдсэн эсэх		
		Сургалтын байгууллагуудын		

		хаяг тодорхой байгаа эсэх	
		<i>Дундаж үнэлгээ</i>	
5	Шинэ санаачилга, үр дүн	Шинэ техник, технологи, инноваци нэвтэрсэн байдал	Авбал зохих оноо 10.0
		<i>Дундаж үнэлгээ</i>	
6	Үйл ажиллагааны ил тод байдал	Ажлын байрны өсөлт, бууралтын түвшин	Авбал зохих оноо 10.0
		<i>Дундаж үнэлгээ</i>	
7	Хөндлөнгийн үнэлгээ	Суралцагчийн үнэлгээ /санал асуулгаар/	Авбал зохих оноо 20.0
		Эрх зүйн орчин болон хөндлөнгийн шинжээчийн хийсэн үнэлгээ, дүгнэлт /Дүүргийн сургалт хариуцсан мэргэжилтэн/	
		<i>Дундаж үнэлгээ</i>	
	Ерөнхий үнэлгээ (Дундаж үнэлгээ+ Дундаж үнэлгээ 2+.....Дундаж үнэлгээ )		

### ҮНЭЛГЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

**Дундаж үнэлгээ** =Шалгуур үзүүлэлт 1+ Шалгуур үзүүлэлт 2+..... Шалгуур үзүүлэлт n / n

**Ерөнхий үнэлгээ**=Дундаж Y<sub>1</sub>\*10+ Дундаж Y<sub>2</sub>\*20+ Дундаж Y<sub>3</sub>\*20+ Дундаж Y<sub>4</sub>\*10+ Дундаж Y<sub>5</sub>\*10+ Дундаж Y<sub>6</sub>\*10+ Дундаж Y<sub>7</sub>\*20/100

Үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээг дараах байдлаар ангилна.

- |                                |            |
|--------------------------------|------------|
| ✓ Бүрэн хангалттай             | 90.0-100.0 |
| ✓ Хангалттай                   | 80.0-89.9  |
| ✓ Ажил сайжруулах шаардлагатай | 70.0-79.9  |
| ✓ Хангалтгүй                   | 0.0-69.9   |

Үнэлгээг үйл ажиллагааных нь хүрсэн түвшин, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, чанар, хүртээмж зэргээс хамаарч 0-оос 100 хүртэл хувиар тооцож холбогдох газарт тайлан мэдээг хүргүүлнэ.

Явцын тайлан мэдээг тухай бүр байгууллагын удирдлагад танилцуулж, хагас, бүтэн жилийн тайлан мэдээг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд хүргүүлнэ.